



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 1129

Шивээговь сум

Сар шинийн баярын хүндэтгэлийн арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.XVII жарны "Хилэнт эх хэмээх модон луу жилийн Сар шинийн баярыг тохиолдуулан сумын ахмадуудад хүндэтгэл үзүүлж, сар шинийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Сар шинийн баярын хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

- П.Ганчимэг
(Эрүүл мэндийн төвийн дарга)
- Г.Гансүлд
(Соёлын төвийн дарга)
- Ш.Чинболд
(Илчлэг Шивээ ААТҮГ-ын захирал)
- Д.Буяндэлгэр
(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)
- Б.Базаррагчаа
(Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга)
- Б.Даваадолгор
(3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)
- Ч.Энхжаргал
(Шивээ Овоо хувьцаат компанийн гүйцэтгэх Хүний нөөцийн албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Баярцэцэг
(Засаг даргын Тамгын газрын нярав)
Б.Алтансүх
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

3.Сар шинийн баярын хүндэтгэлийн арга хэмжээнд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

4.Арга хэмжээнд зарцуулагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.


5.Баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг чанартай зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч. СУГАРМАА

Сумын засаг даргын 2024.07 сарын
31 ний өдрийн
1129 захирамжийн хавсралт



Сар шиний баярын хүндэтгэлийн арга хэмжээнд
зарцуулагдах төсөв

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хэвийн боов	ш	61	7,000	427,000
2	Чихэр	кг	3	26,000	78,000
3	Хорхой ааруул	кг	5	39,000	195,000
4	Айраг	л	80	10,000	800,000
5	Ууц	ш	2	250,000	500,000
6	Нийт дүн				2,000,000

ТӨСӨВ ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН
МЭРГЭЖИЛТЭН:

Б.АЛТАНСҮХ